



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/568

Есөнбулаг сум

Гэрээ шууд байгуулах эрх
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулах ажлын хүрээнд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө үйлчилгээ авах зорилгоор "Эс Ди Жи Консалтинг" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д олгосугай.

2.Хууль зүйн зөвлөгөө үйлчилгээний зардалд шаардагдах 19,600,000 (арван есөн сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ